



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

“Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” батлах тухай 33 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам” батлах тухай 129 дүгээр тогтоол Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг “Ёс зүйн зөвлөл /В.Батчимэг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2019 оны А/18 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

1150500054

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 05 өдрийн
А/14 дугаар тушаалын хавсралт



"ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

В.Батчимэг

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Гишүүн:

Т.Туул

Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Д.Оюун-Эрдэнэ

Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн

--oOo--